



# СУРГАЛТЫН ЯВЦАД УХАМСАР- УЛС ТӨРИЙН СОЁЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ АРГАЗҮЙН ТУХАЙД

«Улс төр бол жинхэнэ утгаараа амьдрал юм»

Освальд Шпенглер

## Abstract

*The renovation of social changes and political system depends on development of political consciousness-culture of intelligentsia which is the independent group of the society. The methodology to build the political consciousness-culture through training process establishes the new research tendency.*

Түлхүүр үг: Сурган хүмүүжүүлэх сэхээтэн (СХС), суурь ухамсар, зуршсан ухамсар, сэдэл- ухамсар, үнэт чанар, үнэт зүйлс, хэрэгцээ, тохироо, улс төрийн соёл

Монголчууд эрт үеэс дэлхийн нүүдэлчдийн соёл иргэншилд үнэт хувь нэмэр оруулж, тодорхой байр сууриа хадгалж ирсэн төдийгүй хойч үеэ сургаж хүмүүжүүлж тэдэнд үндэстний улс төрийн ухамсар, соёлыг төлөвшүүлэх үндэсний онцлог бүхий үзэл баримтлал, арга барил, дадлага туршлагатай билээ.

Монголчууд олон зууны туршид үндэсний уламжлалт улс төрийн ухамсар- соёлоо хадгалж үндэсний тусгаар тогтнол, эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдал, төрийн түвшин амгалан оршихуйн ёсыг танин барьж улс төрийн үйл ажиллагаа явуулж тэмцэж ирсэн түүхэн туршлагатай.

1990-ээд оноос Монгол улс Хүмүүнлэг, энэрэнгүй, иргэний ардчилсан нийгэмд шилжих шилжилтийн үед шилжив. Энэ үеэс нийгмийн шинэчлэлт өөрчлөлт явагдаж Монголын нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан байна. Энэхүү улс төрийн үйл явцын хөгжил, чиг хандлага нь 1980-аад оны дунд үеэс бүрэн шийдвэрлэгдсэн «хүйтэн дайн»-ы үр дагавар болох даяаршийн эрин үетэй холбогдсон юм.

Нийгмийн өөрчлөлт, улс төрийн тогтолцооны шинэчлэлт нь нийгмийн бие даасан сэхээтний бүлэг болох сурган хүмүүжүүлэгч сэхээтний (СХС) улс төрийн ухамсар, соёлын төлөвшил, хөгжлийн чиг хандлагатай нягт холбогдоно.

Аливаа ухамсар эхний шатанд тодорхой хугацаанд оюуны бүтээл болон II шатандаа шинжлэх ухааны түвшинд боловсрогдож ойлголт, категори, хуульзүй тогтол болон III шатандаа гэр бүлийн хүрээнд сургалт- хүмүүжлийн болон мэдээллийн системээр дамжин улмаар олон түмэнд эзэмшигддэг байна.

Массын хүртээл болсон ухамсар нь шинжлэх ухааны хувьд суурь ухамсар (ценностная ориентация), зуршсан ухамсар (установка), сэдэл ухамсар (мотив)-ын хэлбэрээр илэрдэг. Ухамсрын түвшин категориудыг судалж хэрэглээнд оруулж эзэмших нь хүн ямар учраас улс төрийн үйл ажиллагаанд оролцдог болох, хүнийг улс төрийн үйл



**МУБИС - ийн ТНУС - ийн  
Улс төр судлал, социологийн  
тэнхимийн багш, философич,  
доктор (Ph.D), профессор  
Э.Тамир**

ажиллагаанд оролцоход нь ямар хүчин зүйл хэрхэн идэвхжүүлдэг болох зэрэг улс төрийн амьдралд оролцох учир шалтгааныг зөв танин мэдэх, ойлгох, тайлбарлах, дүгнэхэд онол, аргазүйн ач холбогдолтой.

Хүний нийгэмтэй харьцах өдөр тутмын зан авирыг зохицуулж байдаг “суурь ухамсар” хэмээх ойлголтыг 1920-иод онл Америкийн социологич У.Томас, Польшийн социологич Знанецкий нар социологийн хэрэглээнд оруулж, “зан авирыг зохицуулагч ухамсар” гэж үзсэн юм.

Улмаар суурь ухамсар нь XX зуунд Америк болон ЗХУ, Өрнөд Европын социологи, улс төрийн философи, улс төрийн сэтгэл зүйн судлагдахуун болсон байна.

Тухайлбал, «... улс төрийн бүлэг болон хувь хүн нийгмийн нөхцөл байдлыг ойлгож улс төрийн үйл ажиллагааны хийгээд нийгмийн улс

төрийн аль нэг үйл явц үзэгдэлд хандуулсан чиг баримжааны холбогдох аргыг сонгон авч байдаг зуршсан ухамсрын бүхэллэг систем мөн»<sup>2</sup> гэсэн тодорхойлолтыг (хуучнаар) ЗХУ-ын эрдэмтэд өгсөн байна.

Төр, иргэний харилцаа, иргэд хоорондын харилцааг нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн арга барилуудын систем болох “үнэт чанар”-ын тусламжтайгаар зохицуулдаг. “Үнэт чанар”, “үнэт зүйлс” хэмээх ойлголтууд нь улс төрийн шинжлэх ухаанд нэлээд өргөн хэрэглэгддэг. Эдгээр ойлголтууд нь нийтлэг ба өвөрмөц шинжтэй. Нийтлэг шинж нь нийгмийн бодит байдлыг тусгасан хүний сэтгэл санаа, оюуны чадамжыг илэрхийлж байдаг бол өвөрмөц шинж хандлагаараа үнэт зүйлс нь объектив ба субъектив, материаллаг ба оюун санааны талыг, үнэт чанар нь субъектив буюу үзэл санааг илэрхийлж байдаг.

Нийгэм нь үнэт зүйлсийн тогтолцоо хэмээн үзвээс хүнд (СХС-д) үнэт чанарын тухай улс төрийн мэдлэг ухамсар төлөвшүүлэх нь улс төрийн ухамсар-соёл төлөвшихөд ач холбогдолтой.

Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөхөд нийгмийн үнэт зүйлс, үнэт чанарын тухай ойлголт бүхэлдээ өөрчлөгдөж улмаар улс төрийн ухамсар- соёл өөрчлөгдөж хөгжих зүй тогтолтой.

Асуудлыг ингэж авч үзвэл “Суурь ухамсар” нь хувь хүний тухайд улс төр, зан суртахууны өөрчлөгдөшгүй хэмнэл мөн. Хувь хүний эзэмшсэн суурь ухамсар нь улс төрийн үйл ажиллагаа, үзэгдэл, улс төрийн амьдралыг оновчтой ухааран ойлгож, танин мэдсэний түвшин нь, улс төрийн зан байдалд сонголт хийхэд хүний шийдвэр гаргасан шалгуур нь болдог.



Улс төрийн зуршсан ухамсар (установка социальная) нь нийгмийн тодорхой объектод чиглэсэн төдийгүй уг объектод түшиглэн боломжит байдлын сонголт хийж, үйл ажиллагааг явуулах хүний улс төрийн ерөнхий чиг хандлага, баримжааны илэрхийлэл мөн.

Улс төрийн ухамсар соёлын төлөвшил хөгжилд зуршсан ухамсрын эзлэх байр суурь, үүрэг, ямар ач холбогдолтойг танин мэдэх нь чухал.

Зуршсан ухамсар үүсч буй болох зайлшгүй нөхцөл бол хэрэгцээ<sup>1</sup> - тохироо<sup>2</sup> бүрдсэн байх юм. Чухамдаа хүнд ямар нэг хэрэгцээ буй болоход түүнд холбогдол бүхий объектууд субъектэд харьцах хүч нөлөөтэй болж хүнийг дадал зуршлын тодорхой баримтлалын тусламжтайгаар зорилго, чиглэлтэй үйлдэл хийхэд нөлөөлдөг.

Зуршсан ухамсар өөртөө холбогдох нөхцөл буй болмогц дахин шинээр чухалчлагдахад “бэлхэн” шинийг агуулж байдаг.

Зуршсан ухамсар оюун ухааны (когнитивный), сэтгэл санааны (эмоциональный), дадал зуршлын (поведенческий) талуудтай байдаг.

Хувь хүн нийгмийн хүрээллийн үнэт чанарыг эзэмшиж авах замаар нийгэмших үйл явцад нийгмийн зуршсан ухамсар аажмаар төлөвшдөг байна. Төлөвшлийн үйл явц буюу гадаад нөхцөл байдлыг ухамсарлах талаар гарч буй эргэлт нь нийгмийн тохирооны үнэт чанарын системийг сэтгэх үйл явц, бүтээлчээр эзэмшихүйн эхлэл юм.

Нийгмийн орчны үнэт чанарын эзэмшил уг чанартаа итгэл үнэмшил, үзэл, үзэл санааны мэдлэгээр илэрч, нийгмийн зуршсан ухамсрын үндсэн хэсэг болох оюун ухааны талыг бүрдүүлдэг<sup>3</sup>. Нийгмийн зуршсан ухамсрын оюун санааны тал нь юуны өмнө итгэл үнэмшил, үзэл санаа, хувь хүний нийгмийн үйл ажиллагааны талаарх сэтгэхүйн үндэслэл болж байдаг мэдлэгийн бүх баялаг буюу сан юм. Орчин үеийн нийгэмд шинжлэх ухаан, шинжлэх ухааны мэдээлэл, нийгмийн туршлага багтаамжаараа хэдий чинээн өргөн, шинж чанараараа олон янз болсон нь тэдгээрийг тухайлсан харилцааны хүрээнд эзэмших бололцоогүй болгож байна. Өнөөгийн нөхцөлд хувь хүнд зайлшгүй чухал бүх мэдлэгийг эзэмших боломжгүй учраас нийтлэг харилцааны хэрэгсэл нь нийгмийн зуршсан ухамсрын оюун ухааны талыг төлөвшүүлэх цорын ганц биш ч гэсэн гол хүчин зүйл болж байна.

Хүний үйл ажиллагааны мэдлэг, үзэл санаа тодорхойлогч үүрэг гүйцэтгэдэг үү? зуршсан ухамсрын оюун ухааны болон сэтгэл санааны талуудын нэгдэл хэрхэн буй болдог вэ? гэсэн асуулт тулгарч байна.

Судлаачийн үзэж байгаагаар, нийгмийн зуршсан ухамсрын талуудын харьцаа нь нийгмийн үзэл суртал, нийгмийн сэтгэл зүйн харилцан нөлөөллийн ерөнхий зүй тогтолд захирагдаж байдаг. Нийгмийн үзэл суртал нь нийгмийн сэтгэл зүй, үзэл санаа, үзэл, мэдлэг зэргийг тодорхойлдог шиг зуршсан ухамсрын оюун ухааны тал холбогдох сэтгэл санааг төрүүлж байдаг. Яв цав ухамсарлагдсан танин мэдэгдсэн үнэт чанар сэтгэл санааны эрчимтэй өөрчлөлт дагуулдаг нь туршилтаар батлагдсан үнэн юм.

Гурван талын нэг буюу дадал зуршил нь оюун

ухаан, сэтгэл санааны талууд болох нийгмийн зуршсан ухамсар хүний үйл ажиллагаанд шууд зохицуулагч үүргийг гүйцэтгэдэг. Гэхдээ үзэл, үзэл санаа, мэдлэг нь итгэл үнэмшил болж хувирсан гагцхүү тийм тохиолдолд л зуршсан ухамсар өөрийн үүргийг жинхэнэ ёсоор гүйцэтгэж чадах юм.

Ингэхлээр өсвөрийн, залуу үед улс төрийн ухамсар, соёл төлөвшүүлэх гол зорилт бол юуны өмнө бидэнд улс төрийн итгэл үнэмшил төлөвшүүлэхтэй холбогдоно.

Нийгмийн зуршсан ухамсрын хоёрдахь чухал хэсэг бол сэтгэл санааны тал юм. Сэтгэл санааны тал нь тухайн харилцаан дахь хувь хүний сэтгэл догдлол, “сэтгэл татагдал”<sup>4</sup> мөн хэмээвээс зуршсан ухамсрын сэтгэл санааны тал нь түүний угтал болсон оюун ухааны талтай диалектик хэрэгжүүлэн биелүүлэх ёстой ирээдүйн үйл ажиллагаа, зорилго бол итгэл үнэмшлийн идэвхтэй зуршсан ухамсар буюу идэвхийг хэрэгтэй зүйл рүү хүч болгон хувиргах явдал юм. Аливаа сэтгэл хөдлөл нь хүнийг асар их хүчтэй болгох, идэвхтэй үйл ажиллагаанд өдүүлэх чадвартай. Эндээс зан суртахууны болон оюун ухааны хийгээд сэтгэл хөдлөлийн хүмүүжлийн чухал ач холбогдол урган гардаг. Нийгмийн зуршсан ухамсрын чухал тал болсон сэтгэл, сэтгэл хөдлөл, сэтгэл санаа бол жирийн сэтгэл, сэтгэл санаа биш. Эдгээр нь субъектийн жинхэнэ сэтгэл догдлол болох ёстой, субъектийн хэрэгжүүлэн биелүүлэх ёстой ирээдүйн үйл ажиллагаа, сэтгэл догдлуулсан идэвхийлэл юм. Чухалчлагдах мөч бол энэхүү сэтгэл догдлолын өвөрмөц илрэл мөн<sup>5</sup>.

Нийгмийн зуршсан ухамсар дээр дурьдсан хоёр талаас гадна гурав дахь буюу дадал зуршлын талтай. Энэ нь “практик дээр урдах хоёр талтай холбоотойгоор тухайн харилцааны чиглэлээр ажиллах хандлага буюу бэлэн шинж чанар”<sup>6</sup> юм. Дадал зуршлын тал ямар шалтгаанаар урдах хоёр талаа дагалдаж байдаг тухай асуултыг тогтож тайлбарлах шаардлагагүй гэж үзэж байна. Энэ талаар зуршсан ухамсрын оюун ухааны талтай холбоо бүхий үйл ажиллагаанд, тухайн харилцаанд “сэтгэл татагдсан”-ы улмаас хүн “тулгамдсан мөч” буюу чухамдаа тухайлсан харилцааны чиглэлээр ажиллах бэлэн байдалд ордог юм.

Нийтлэг харилцааны буюу үзэл санаа, итгэл үнэмшил болж хувирсан тохиолдолд хүмүүсийн хоорондын тухайлсан харилцаа нь сэтгэл санааны болон дадал зуршлын талуудын төлөвшлийн чухал хүчин зүйл болдог. Бэлэн байдал, жинхэнэ дадал чадвар зэргийг хамааруулдаг сэтгэл санаа, дадал зуршил, сэтгэлгээний арга замаар төдийгүй гол төлөв тодорхой нөхцөлд, жинхэнэ үйл ажиллагаагаар, тодорхой хувь хүмүүс, үзэгдэлтэй харилцах харилцааны явцад төлөвшдөг. Янз бүрийн түвшинд явуулсан социологийн тодорхой судалгааны дүн хамт олны дотоод харилцаа өсвөрийн хийгээд залуу үеийн дадал, чадварын төлөвшилд үлэмж нөлөөтэйг харуулсан байна<sup>7</sup>. Дээр дурьдсанаас үзэхэд зуршсан ухамсрын гурван талын аль нэг дутагдахад уг ухамсрын төлөвшилт хангалтгүй болно. Хэрэв нэрлэсэн талуудын хооронд нэгдэлгүй өөр хоорондоо холбоогүй бол зуршсан ухамсрын тухай үг яриа байж болохгүй<sup>8</sup> юм.

Тухайлсан ба нийтлэг харилцааны диалектик харилцан хамаарал нь нийгмийн зуршсан ухамсрын эдгээр гурван талын нэгдлийг зайлшгүй болгодог байна. Нийгмийн харилцаануудын нэг төрлийг нөгөөгөөс нь өрөөсгөлөөр хэтрүүлэн үзэж болдоггүйн адил зуршсан ухамсрын

<sup>1</sup> Хэрэгцээ гэдэг ойлголтоор оршин байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаанд хүргэдэг биологи-нийгмийн болон нийгмийн системийн объектив шаардлагыг авч үзэж байна.

<sup>2</sup> Тохироо хэмээх ойлголтоор хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны тодорхой нөхцөл, нийгмийн орчныг авч үзэж байна. Нийгмийн хүрээнд нийгмийн зуршсан ухамсар илэрч, хэрэгждэг. Нийгмийн тохироо гэж олон түмэн хийгээд өсвөрийн залуу үеийнхний өөр хоорондын харилцааны тодорхой төрлийг ойлгож гэмдэглэж байна.



талуудыг нэгдэлд нь авч үзэх ёстой. Хэрэв тухайлсан харилцааны хэрэгслэлийг өрөөсгөлөөр хэрэглэсний улмаас хувь хүнд зуршсан ухамсрын оюун ухааны тал хангалттай төлөвшөөгүй ч гэсэн нийгмийн идэвхтэй байж болно. Гэхдээ түүнд ажил хэргийн мэдлэг, үйл ажиллагааны чиг баримжаа дутагдана. Хэрэв зуршсан ухамсрын сэтгэл санааны болон дадал зуршлын талууд дутагдвал харилцааны сэтгэл зүй, дадал зуршлын төрлүүдийг буруу хослосны уршгаар тэр нь мэдлэг, үзэл санааны зарим нөөцийг эзэмшлээ ч гэсэн идэвхгүй байдаг. Чухам ийм учраас хүүхэд залуучуудын сургалт хүмүүжилд тухайлсан ба нийтлэг харилцааг оновчтой хослох зайлшгүй шаардлагатай юм.

Хүний дадал зуршил нэг л янз ухамсрын суурин дээр зохион байгуулагддаггүй. Нэг зуршсан ухамсар үүргээ биелүүлээд нөгөөдөө, нөгөөх нь дараагийнхдаа байраа тавьж өгдөг юм. Зуршсан ухамсрын халагдал солигдол бол суурь ухамсрын үндэс юм. Үүний ачаар зуршсан ухамсарт байдлын цар хүрээ өсөн нэмэгдэж, хөгжиж байдаг байна. Ингэхлээр хүний зуршсан ухамсарт байдал суурь ухамсар болон төлөвшсөн зуршсан ухамсрын бүхэл бүтэн тогтолцоо болж хөгждөг байна.

Ийм утгаар суурь ухамсрыг зуршсан ухамсрын системд хамааруулдаг. Суурь ухамсар зуршсан ухамсрын системд хамаарагдсанаар оюун ухаан эргэл санаа, дадал зуршлын талуудаар тодорхойлогддог нь эргэлзээгүй юм.

Сэдэл ухамсар (францын *motif* побуждение) субъект (бие хүн, нийгмийн бүлэг, хүмүүсийн нийтлэг)-ийн тодорхой хэрэгцээг хангах эрмэлзэлтэй холбоотой идэвхийлэл, үйл ажиллагаагааны өдүүлбэр юм. Сэтгэлзүйд сэдэл нь субъектийг өдүүлэгч дотоод, гадаад нөхцлүүдийн нэгдлийг болон ухамсарласан буюу ухамсарлаагүйгээр уг идэвхийлэл чиглэж байдаг юмс буюу объектыг тэмдэглэдэг ажээ.

Сэдэл нь үйл ажиллагаанд хүссэн нөхцөлийг буй болгох, тодорхой ашиг олох гэсэн субъектийн ухамсарласан хэрэгцээг авч үздэг. Хувь хүмүүсийн хийгээд нийгмийн нийтлэгүүдийн идэвхийллийн дотоод өдүүлбэр болсон сэдлийг гадаад өдүүлбэрүүд – субъектийн санаа бодлоор ач холбогдолтой болж хэрэгцээнд нийцэж буй тохиолдолд сэдэл болдог объектив нөхцөлүүдийн нөлөөлөл буюу өдүүлбэрүүдээс ялгаж үзэх хэрэгтэй. Субъектээс хамааруулан сэдлийг хувь хүмүүсийн, бүлгүүдийн, нийгмийн хүрээний нийтлэгүүдийн (тухайлбал ангиудын) гэж ялгадаг; хэрэгцээг хангаж буй объектоор нь материалын, оюун санааны; илүү жижигрүүлсэн ангиллаар нь эдийн засаг, социаль, үзэл суртал, оюуны; бүр нарийвчлан тухайлбал, эдийн засгийн салбарт үйлдвэрлэл, солилцоо, хэрэглээтэй холбоотойгоор нь; оюуны салбарт зан суртахуун, гоозүй; үйл ажиллагааны үндсэн төрлөөр нь танин мэдэхүй-оюун ухааны, практик өөрчлөн байгуулалтын, харилцаа холбооны гэх мэтээр ангилж болох юм. Сэдлийн гол ангилал, субъектийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлогч хамгийн ерөнхий (амьдрахуйн концепц, үнэт чанарын систем)-ээс тухайн тодорхой тохироон дахь зарим хэсгийн хэрэгцээг хангахтай, түүнчлэн нийгмийн нарийн төвөгтэй үйл ажиллагаанд өдүүлэгч, олон янзын сэдлүүдтэй холбоотой сэдлийг хүртэх байдлаар хэрэгждэг. Тийм системүүд (цогцолбор) дэх сэдлүүд тэргүүлэх, зонхилох буюу захирагдангүй, орон нутгийн шинжтэй байж болно. Судалгааны арга зүйн сэдэл нь үзэл санааны үндсэн эерэг ба сөрөг, томоохон чиглэлүүдтэй сөргөлдөх явдал их тохиолддог. Сэдлийн судалгаа хүн амын янз бүрийн хэрэгцээ, түүнийг хангах нөхцөлийн судалгаатай нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх, хүмүүсийн идэвхийг өрнүүлэх, нийгмийн сөрөг үзэгдэл, дадал зуршлын гажгийг

даван туулах ажлыг эрчимжүүлэхтэй шууд холбогддог.

Улс төрийн шинжлэх ухаанд “улс төрийн ухамсар соёл”-ыг олон талаас нь авч үзэж тайлбарлаж ирсэн байна.

Шинжлэх ухааны утга зохиолд улс төрийн ухамсар соёлыг үзэл суртал, давхаргын үзэгдэл, соёлын онцгой төрөл, нийгэм улс төрийн амьдралд болон улс төр, нийгмийн институтууд, тэдгээрийн үйлчлэл хөгжлийг хангахад иргэдийн оролцооны мэдлэг, дадлага, үзэл, үнэт чанарыг тодорхойлогч, нийгмийн язгуур ашиг сонирхолын хэрэгжилтийг илэрхийлсэн оюун ухаан, практик үйл ажиллагаа, харилцааны чанар, арга барил, бүтэц элемент, түвшин юм гэж тэмдэглэсэн байна<sup>9</sup>.

Улс төрийн соёлыг “хууль, дадал заншил ангийн ухамсарт тэмдэглэгдсэн түүхэн туршлага”<sup>10</sup> мөн гэсэн Ф.М.Бурлацкий, А.А. Галкин нарын тодорхойлолтыг М.Т.Иовчук, Л.Н.Коган нар улс төрийн соёл “нийгэм улс төрийн харилцааны хүрээнд дэх хүмүүсийн үйл ажиллагааны арга”, “нийгэм-улс төрийн үзэл санаа, мэдлэг, итгэл үнэмшлийг эзэмшсэний болон тэдгээрийг нийгэм-улс төрийн үйл ажиллагаанд хэрэглэх чадварын түвшин”<sup>11</sup> мөн гэсэн тодотголоор баяжуулсан байна.

Ф.М.Бурлацкий “улс төрийн соёлыг олон янз байдлаар нь улс төрийн уламжлал, улс төрийн чиг баримжаа, улс төрийн үнэт чанарын систем, улс төрийн үзэл суртал, улс төрийн билэг тэмдэг, хэм хэмжээ, стандарт хэв загвар, чиг баримжааны хэв маягуудын түүхэн гарал, үүслийн шинж байдал гэх зэрэг”<sup>12</sup>-ээр нэрлэж болох юм хэмээн тэмдэглэсэн байна.

Ц.Ганбат “Улс төрийн соёл бол нийгмийн улс төрийн системийн улс төрийн сэтгэлгээ, ухамсар, үүрэг, үйл ажиллагааны хөгжил, улс төрийн үйл ажиллагаа, иргэдийн хүсэл зоригийн илэрхийлэлд оролцогч субъектүүд тэдгээрийг эзэмшсэний түвшин, үйл хэргийн дүр төрхийн байдал, шинэ хэрэгцээтэй холбоо бүхий тухайн улс төрийн соёлын харилцаа, үнэт чанарын өөрчлөлт юм”<sup>13</sup> гэж үзсэн байна.

Ю.А.Красиныхаар улс төрийн соёл нь “Өөртөө улс төрийн мэдлэг, эрх ба үүргийн мэдлэг, нийгмийн үйлчлэлийн хэм хэмжээ, удирдлагын зарчим, арга, дадлага эзэмшилт, нийгмийн удирдлагын үйл хэрэгт оролцох эрмэлзлэл, зуршил, дотоод хэрэгцээг агуулж байдаг”<sup>14</sup> гэж үзсэн бол В.А.Шегорцев “Засаг, удирдлагын асуудлыг аль нэг хэмжээгээр хөндөж байдаг үйл ажиллагаа, зохион байгуулалтын төрлүүд, нийгмийн холбогдох харилцааг хамаарсан нийгмийн улс төрийн олон талт амьдралыг улс төрийн соёлын үйлчилгээний хүрээ”<sup>15</sup> гэж үзсэн байна.

Улс төрийн соёлыг аль нэг хэв маяг хэрэгжиж байдаг улс төрийн тогтолцоог илэрхийлэгч нийгмийн үзэгдлүүдийн тодорхой мөн чанар мөн гэж тодорхойлсон нь ч байна. Зарим судлаачид улс төрийн соёл бол эд өлгийн ч, оюуны ч соёлд хамааруулж болохгүй соёлын онцгой төрөл; тухайлбал, соёлын харилцан холбоог эд өлгийн, улс төр, оюуны соёл гэж ялгаж үзсэн нь ч байна. Соёлыг онолын, аргазүйн, аргын гэж ялгаварладаг байна. Сүүлчийн тодорхойлолтын ач холбогдолыг үгүйсгэлгүйгээр өгүүлэхэд, улс төрийн соёлыг ерөнхий соёлын төрлүүдээс хийсвэрлэн салгах үндэслэлгүй юм. Л.Н.Коганы тэмдэглэснээр, “Соёлын бүх төрөл-эд өлгийн болон оюуны соёлыг дараалуулан хэвтээгээр нь байрлуулбал уг байршилд улс төрийн соёл «босоо огтлол» болж харагдана”. Үүний зэрэгцээ **улс төрийн соёл нь соёлын онцгой, тусгай дэд систем болж оршдог болохоор хүмүүсийн нийгмийн үйл ажиллагааны онцгой төрөл болж, нийгэм**



**улс төрийн үйл ажиллагааг тусгадаг.** Улс төрийн ухамсар соёлыг төлөвшүүлэх, эзэмшүүлэх талаар өрнөдийн улс төр судлаач- эрдэмтэдийн бүтээлүүд, шинжлэх ухааны хийгээд арга зүйн асар их үнэ цэнэтэй юм. Америкийн улс төр судлаач Г.Алмонд “улс төрийн соёлыг улс төрийн системийн оршин тогтнох арга төдийгүй улс төрийн үйл ажиллагаан дахь чиг баримжааны онцгой загвар гэж үзсэн. Улс төрийн чиг баримжаа нь өөртөө мэдлэг, оюун ухаан, гадаад харилцаа, тохироонд зохицох зохицол, ерөнхий соёлын хэв маяг, үнэт чанарыг агуулж байдаг болохоор соёлын ялгарал болж тодорхой шинжийг хадгалж байдаг байна. Энэхүү тогтолцооны үйл ажиллагааны зөв нөхцөлүүд бол: а) гэр бүлээс эхлээд улс төрийн соёлын уламжлагдах ёсыг хэрэгжүүлж байдаг сүм хийдийг хүртэлх байгууллагуудыг дамжин хэрэгжигч соёлын ялгармал хэсэг; б) улс төрийг мэргэшсэн жүжгийн роль болгон ашиглахийн тулд хувь хүмүүсийн хийдэг сонголт; в) улс төрийн намуудын хэв маягийн янз бүрийн бүлэг- нэгдлүүдээр дамждаг ашиг сонирхолын хууль ёсны зөвлөмж; г) улс төрийн харилцаа холбооны бүтэц зохион байгуулалт; д) хууль тогтоох, гүйцэтгэн захирах, шүүх үүргийн биелэлт юм”<sup>16</sup> гээд, Г.Алмонд, С.Верба нар үндэстний улс төрийн соёл тухайн үндэстний доторхи улс төрийн объектуудын харилцаан дахь чиг баримжааны загваруудын онцгой хуваарилалт гэж авч үзсэн юм. С.Верба нийгмийн улс төрийн соёл улс төрийн үйлдэл явагддаг тохироог тодорхойлогч билгэ тэмдэг, үнэт чанарыг илэрхийлсэн улс төрийн итгэл үнэмшлийн системүүдээс бүрэлдэж тогтдог гэж үзжээ<sup>17</sup>. Г.Алмонд, С.Верба нар улс төрийн соёлын хувийн чиг баримжааг I. Танин мэдэхүйн түвшин- улс төрийн системийн тухай мэдлэг, сэтгэгдэл; II. Сэтгэл хөдлөлийн түвшин- улс төрийн системд хандах хандлага, мэдрэмж; III. Үнэлгээний түвшин- улс төрийн объектуудын талаарх бодомж, сэтгэгдэл гэж ангилж үзсэн байна. Польшийн улс төр судлаач М.Соболевский улс төрийн соёлд: I. Системийн зүгээс эрмэлзэн тэмүүлж байх ёстой улс төрийн үйл ажиллагааг тодорхойлогч үнэт зүйлс; II. Улс төрийн үйл ажиллагааны үндсэн аргууд, хувь хүн- тодорхой бүлгийн улс төрийн үйл байдлын хэм хэмжээ; III. Улс төрийн үндсэн элементүүд зэргийг багтаажээ<sup>18</sup>.

Варшавт хэвлэгдсэн «Улс төрийн шинжлэх ухаан» хэмээх сурах бичигт: “улс төрийн соёлыг улс төрийн амьдралын янз бүрийн утга санааны тухай түүхэн ёсоор төлөвшсөн ил ба далд төсөөллийн цогц систем мөн гэсэн баталгааг гаргасан байна. Үүнд а. Үнэт зүйлс, б. Хэм хэмжээ, в. улс төрийн институтууд. г. Загвар, д. Хувь хүмүүсийн болон нийгмийн бүлгүүдийн улс төрийн үйл ажиллагааны арга багтана”<sup>19</sup> гэж үзжээ.

Улс төрийн соёл маш өргөн хүрээ, гүнзгий агуулга бүхий ойлголт юм. Улс төрийн соёл нь элементүүдийн аль нэгийг нь хийсвэрээр туйлчлах болон улс төрийн соёлыг гагцхүү сэтгэл зүйн хүрээнд авч үзэх буюу сэтгэл зүйн үзэгдэл мэт ойлгох боломжгүй. Иймд улс төрийн соёлын тодорхойлолтыг янз бүрийн шалгуур хэрэглэн шинжилж болох юм. Тухайлбал, улс төрийн соёлын судлах зүйлийн тодорхойлолтыг өргөн ба явцуу гэж ангилах бололцоо олгодог цар хүрээний шалгуур; улс төрийн соёлын субъектүүдийн үүрэг, шинжийг тодорхойлж байдаг субъектийн шалгуур; улс төрийн соёлын тодорхойлолт дахь туслах шинж бүхий зүйл (улс төрийн систем, улс төр, засаг, улс төрийн институтууд, үзэл санаа)-ийн харьцуулалтуудын шалгуурууд багтана.

Зохиогчийн бодлоор “Улс төрийн соёл бол төр, засаг ба улс төрийн тухай, төр засаг ба иргэдийн харилцааны тухай, нийт хүн ам, тэдгээрийн янз бүрийн бүлэг, хэсгүүдийн мэдлэг, итгэл үнэмшил, үнэлэлт, засаглалд харьцах сэтгэлийн

хөдөлгөөн, засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох зан авир, идэвхтэй ба идэвхгүй, эерэг ба сөрөг үйл ажиллагааны нэгдэл юм”<sup>20</sup>. Улс төрийн соёлд өгсөн тодорхойлолтод тулгуурлан бүрэлдэхүүн хэсгүүд ба элементүүдэд түршлагын хийгээд онол, шинжлэх ухааны мэдлэг, итгэл үнэмшил, үнэт чиг баримжаа, байр суурь, сэтгэлийн хөдөлгөөн, зан авир, улс төрийн идэвхтэй ба идэвхгүй үйл ажиллагаа, олон улсын харилцаа буюу дэлхийн улс төрийн амьдралд хандах хандлага зэргийг оруулж байна. Улс төрийн соёлын бүхэлдэхүүн хэсгүүдийг шинжлэн авч үзэх нь сэхээтэн, сурган хүмүүжүүлэгч сэхээтний төлөвшлийн үйл явцын диалектикийг харуулах аргазүйн ач холбогдолтой юм.

Улс төрийн соёл төлөвшин хөгжиж ирсэн нийтлэг зүй тогтол, жам ёс байдаг боловч тухайн улс орны түүхэн уламжлал, үндэсний онцлог үндэсний хэм хэмжээ зэргээс шалтгаалан дахин давтагдашгүй өвөрмөц онцлог, зайлшгүй ба санамсаргүй, объектив ба субъектив шинж бүхий зөрчил байна. Улс төрийн соёлыг нийгмийн ухамсрын нэг хэлбэр гэж үзэж задлан шинжлэх нь түүнийг төлөвшүүлэх зүй тогтлыг танин мэдэх, тодорхойлон илэрхийлэх олон талын ач холбогдолтой юм. Ухамсар- улс төрийн ухамсар соёлыг иргэдэд юуны өмнө сурган хүмүүжүүлэх сэхээтэнд болон залуу үед төлөвшүүлэхийн тулд нийгмийн харилцааны бүх салбарт холбогдох оновчтой бүтэц хэлбэр, механизмыг боловсронгуй болгох нь чухал юм. Юуны өмнө багш нарт улс төрийн ухамсар соёлыг төлөвшүүлэхдээ улс төрийн мэдлэг эзэмшүүлэх шаардлагатай. Төлөвшилт нь хоёр замаар явагдана. 1-рт, төр засаг, улс төрийн тогтолцооны талаарх мэдлэг, төрийн бодлого, төрийн үйл ажиллагааг урсгал байдлаар мэдрэх аргаар мэдэж төсөөлдөг. Энэ байдал нь нийгмийн харилцаа ихээхэн улс төржсөн өнөөгийн нөхцөлд тодорхой ажиглагдаж байна. Ийм мэдлэг улс төрийн ухамсар соёлыг төлөвшүүлэхэд хангалтгүй. Тухайлбал, сонгуулийн утга учир, ач холбогдолыг мэддэггүй сонгуулийн насанд хүрсэн иргэн хувь заяагаа тодорхой хугацаанд субъектэд даатгаж төрийн эрх барих дээд байгууллагын төлөөлөгчдийг сонгоход ихэвчлэн итгэл үнэмшилгүй, механикаар, тухайлбал, аялдан дагалдах, хууртах, дарамт хавчлагад орох байдлаар оролцдог нь тодорхой юм. 2-рт иргэдэд улс төрийн мэдлэг боловсролыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр багш нарын тусламжтайгаар дэс дараатай, системтэй, онол практикийг хослуулсан байдлаар эзэмшүүлэх шаардлагатай. Ийм учраас улс төрийн боловсрол нь шударга мэдээлэл, мэдээллийн хэрэгсэлд тулгуурлан, улс төр судлал, улс төрийн философи, хуулийн шинжлэх ухаануудын сургалтын явцад шийдвэрлэгдэх юм. Улс төрийн мэдлэгийн үндсэн дээр улс төрийн итгэл үнэмшил, чиг баримжаа, улс төрийн сэдэлтэй болж, улмаар улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

Улс төрийн үйл ажиллагаанд оролцох ухамсар улс төрийн мэдлэг оролцоо бол тэдний улс төрийн ухамсар-соёлыг тодорхойлох хүчин зүйл болж байна.



## НОМЗҮЙ

- Лавай сэтгүүл. МУБИС. УБ., 2006. 53-60-р тал
- А.В.Петровский, В.В.Шпалинский. "Социальная психология коллектива". М., 1978, с-69
- З. Личность и ее ценностные ориентации. Информационный бюллетень. №4 /19/. Вып., САА., институт. КСИ. М., 1969, с-39
- Д.Н.Узнадзе. Психологические исследования. С386
- Личность и ее ценностные ориентации. Информационный бюллетень. №4 /19/. Вып., САА., институт. КСИ. М., 1969, с-40
- Н.Хавх. Проблемы межличностного и массового общения в студенческой молодежи (Диссертация на соискание ученой степени кандидата философских наук), Уб., 1984. с-103
- В.И.Камаровский. Некоторые проблемы теории и опыт конкретного исследования социальных установок. Диссертация на соискание ученой степени кандидата философских наук. М., 1969. с-51
- Кейзеров Н.М. Политическая и правовая культура. М., 1983. с-14
- Ф.М.Бурлацкий. А.А.Галкин. Социология, политика, международные отношения. М., 1974, с-113
- Иовчук М.Т. Советская социалистическая культура: исторический опыт и современные проблемы. М., 1979 с-38-39. Л.Коган. Политическая культура "Научный коммунизм". М., 1979, с-15
- Ф.М.Бурлацкий. Ленин, государство и политика. М., 1985. с-109
- Ц.Ганбат. Политическая культура Монгольского общества в условиях обновления. Диссертация на соискание ученой степени кандидата философских наук. М., 1991, с-13
- Ю.А.Красин. Участия трудящихся в управлении "профессионализм". Вопросы философии. 1982. №4, с-14
- В.А.Шегорцев. Политическая культура как элемент духовной жизни развитого социалистического общества. "Проблемы научного коммунизма". 981. №4, с-45-46
- Almond.G. Comparative Political System. Journal of Politics. 1956, Vol. 18, N3, p-396
- Almond.G, Verba.S. The civil Culture Political Attitudes and Democracy in Five Nations Boston, 1965, p-13
- Политическая вчера и сегодня. М., 1990. С-218-219
- Политическая вчера и сегодня. М., 1990. С-219
- Э.Тамир. Монголын сэхээтний улс төрийн ухамсар соёлын төлөвшлийн зарим асуудал. (СХС-ний жишээн дээр). Уб., 1993